



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.15 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.6 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн баримт бичгийг бүртгэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны сонгуулийн хороодын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “Сонгуулийн баримт бичгийг бүртгэх” журам батлах тухай 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГЛИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

0000029

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны дугаар сарын 15-ны өдрийн
15. дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хороо болон төв, салбар комисс /цаашид “сонгуулийн хороод” гэх/ сонгуулийн холбогдолтой баримт бичгийг /цаашид “баримт бичиг” гэх/ бүртгэх, эмхлэн цэгцлэх, хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгуулийн холбогдолтой баримт бичгийг бүртгэх, эмхлэн цэгцлэх, хүлээлцэх үйл ажиллагаанд сонгуулийн тухай болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

Хоёр. Сонгуулийн холбогдолтой баримт бичиг, түүнийг бүртгэх

2.1. Сонгуулийн хороодын үйл ажиллагааны явцад захирамжлалын болон зохион байгуулалтын шинжтэй дараах баримт бичгийг бүртгэнэ. Үүнд:

2.1.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, төв комиссын тогтоол;

2.1.2. аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны болон төв комиссын даргын захирамж;

2.1.3. сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл;

2.1.4. сонгуулийн хороодын ажлын төлөвлөгөө, тайлан;

2.1.5. ирсэн болон явсан албан бичиг;

2.1.6. өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн талаарх мэдээ, тайлан;

2.1.7. сонгуулийн төсвийн хуваарилалт болон зардлын тайлан, тэдгээрт холбогдох баримт;

2.1.8. сонгуульд нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой баримт бичиг;

2.1.9. нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн ерөнхий менежер, менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагчийн бүртгэл, тэдгээртэй холбогдох баримт бичиг;

2.1.10. саналын хуудас;

2.1.11. саналын хуудас хүлээлцсэн тэмдэглэл, зарцуулалтын тайлан, мэдээ;

2.1.12. ирцийн мэдээ болон санал өгсөн сонгогчдын нас, хүйсийн судалгаа;

2.1.13. санал тоолох төхөөрөмжийн үр дүнгийн тайлан.

2.1.14. санал хураалтын дүнгийн нэгтгэл;

2.1.15. хяналтын тооллоготой холбоотой баримт бичиг;

2.1.16. сонгогдсон гишүүд, төлөөлөгчдийн хөрөнгө орлогын мэдүүлэг;

2.1.17. сонгуулийн зохион байгуулалттай холбоотой үйлдсэн бусад баримт бичиг.

2.2. Сонгуулийн баримт бичгийг бүртгэхдээ тухайн баримт бичгийн огноо, дугаар, гарын үсэг, тамга, тэмдэг зэрэг баримт бичгийн бүрдэл нь тухайн баримт бичигт тавигдах шаардлага хангасан эсэхийг нягтална.

2.3. Сонгуулийн хороод хүлээн авсан баримт бичгийг бүртгэлийн дэвтэрт төрөл тус бүрээр нь бүртгэнэ.

2.4. Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийн огноо, дэс дугаар, агуулгыг өөрчлөх, солих, засвар оруулах, бичигдсэн зүйлийг дарах, устгахыг хориглоно.

Гурав. Сонгуулийн холбогдолтой баримт бичгийг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх

3.1. Сонгуулийн хороод нь сонгуулийн холбогдолтой баримт бичгийг эмхлэн цэгцлэх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх үйл ажиллагаанд архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан холбогдох журам, зааврыг мөрдөнө.

3.2. Хадгаламжийн нэгж бүрдүүлэхэд дараах шаардлагыг баримтлана:

3.2.1. Баримт бичгийг он цаг, асуудал сэдвээр нь ангилан төрөлжүүлнэ.

3.2.2. Баримтын хадгалах хугацаагаар ангилан, байнга хадгалах, түр хадгалах баримтаар тус тусад нь хадгаламжийн нэгж бүрдүүлнэ.

3.2.3. Хадгаламжийн нэгжид албан ёсны бүрдэл бүхий зөвхөн нэг хувь, эх баримт бичгийг оруулна.

3.2.4. Байнга хадгалах хадгаламжийн нэгж нь 250 хүртэл хуудастай байх бөгөөд хадгаламжийн нэгжийн хуудас 250-иас илүү гарвал тэдгээрийг хэд хэдэн боть болгоно.

3.2.5. Хадгаламжийн нэгж бүрт дотоод товьёог, баталгааны хуудсыг заавал хийнэ. Дотоод товьёогийн хуудас бүрийг дугаарласан байна.

3.2.6. Хадгаламжийн нэгжийн хуудас бүрийн баруун дээд өнцөгт балын харандаагаар, араб тоогоор дугаар алгасахгүй дугаарлана. Баримт бичиг нь ар, өвөргүй бичвэртэй тохиолдолд ар, өвөргүй дугаарлана.

3.2.7. Хадгаламжийн нэгжийн хавтасны тодорхойлолт буюу нүүр бичилтийг Сонгуулийн ерөнхий хороо нэгдсэн журмаар хийнэ.

Дөрөв. Сонгуулийн холбогдолтой баримт бичгийг хүлээлцэх

4.1. Хэсгийн хороо нь энэ журмын 2.1-д заасан баримт бичгээс эрх хэмжээнийхээ хүрээнд үйлдсэн баримт бичгийг санал хураалт дууссанаас хойш гурав хоногийн дотор сум, дүүргийн сонгуулийн хороонд баримтаар хүлээлгэн өгнө.

4.2. Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комисс нь энэ журмын 2.1-д заасан баримт бичгээс эрх хэмжээнийхээ хүрээнд хамаарах баримт бичгийг хэсгийн хороодоос ирүүлсэн баримт бичгийн хамт хэсгийн хорооноос хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор дээд шатны сонгуулийн хороонд баримтаар хүлээлгэн өгнө.

4.3. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо энэ журмын 4.4-т зааснаас бусад баримт бичгийг сум, дүүргийн сонгуулийн хороодоос ирүүлсэн баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн архивт холбогдох журмын дагуу хүлээлгэн өгнө.

4.4. Аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хороо дараах баримт бичгийг санал хураалт дууссанаас хойш арав хоногийн дотор холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж үүсгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө:

4.4.1. санал хураалтын дүнгийн нэгтгэл;

4.4.2. хэсэг дэх санал тоолох төхөөрөмж бүрээс хэвлэгдсэн санал хураалтын үр дүнгийн тайлан;

4.4.3. санал хураалтын ирцийн мэдээний нэгтгэл, санал өгсөн сонгогчийн нас, хүйсийн судалгаа;

4.4.4.санал хураалтын ирц бүртгэлийн хаалтын тайлангийн хуудсыг сонгуулийн хэсэг тус бүрээр;

4.4.5.саналын хуудас хүлээн авсан мэдээ, зарцуулалтын тайлан;

4.4.6.ажиглагчийн тоон мэдээний нэгтгэл;

4.4.7.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар санал өгсөн сонгогчийн тоон мэдээний нэгтгэл;

4.4.8.хяналтын тооллогын талаарх мэдээний нэгтгэл;

4.4.9.хяналтын тооллого хийсэн тухай хэсгийн хорооны тэмдэглэл, тухайн хэсэг дэх санал тоолох төхөөрөмж бүрээс хэвлэгдсэн санал хураалтын үр дүнгийн тайлангийн хамт;

4.4.10.сонгуулийн хороодын ажлын тайлан.

4.5.Сонгуулийн ерөнхий хороо аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдогчдын нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг тухайн шатны сонгуулийн хороодоос хүлээн авч, нэгдсэн журмаар Авлигатай тэмцэх газарт хүлээлгэн өгнө.

4.6.Төв комисс дор дурдсан баримт бичгийг эмхлэн цэгцэлж, санал хураалт дууссанаас хойш долоо хоногийн дотор холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж, Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө:

4.6.1.санал хураалтын ирцийн мэдээний нэгтгэл;

4.6.2.саналын хуудас хүлээн авсан мэдээ, зарцуулалтын тайлан;

4.6.3.ажиглагчийн тоон мэдээний нэгтгэл;

4.6.4.саналын хуудас;

4.6.5.төв комиссын ажлын тайлан.

4.7.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс нь сонгуулийн зардлын тайланг хуульд заасан хугацаанд багтаан Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

4.8.Энэ журмын 4.4, 4.6-д заасан баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх бөгөөд цахим хувийг Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийн нэгдсэн санд хадгална.

Тав. Хариуцлага

5.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оо---